МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Санхүүгийн дотоод аудит
Хамрагдсан байгууллага: Дорнод аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар
Тайлангийн код: ХШҮДАГ-2025/ДА/18

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР 1
1.ТАНИЛЦУУЛГА 2
1.1. Байгууллагын тухай 2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ 3
2.1. Аудитын зорилго: 3
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт 3
2.3. Аудитын арга, аргачлал 3
2.4. Өмнөх шалгалтын талаар 3
3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ 4
3.1. Засаглалын удирдлагын талаар 4
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар 4
3.3. Дотоод хяналтын талаар 4
4. Санхүүгийн үйл АЖИЛЛАГААНЫ талаар 5
5. АУДИТЫН ҮР ДҮН 7
5.1. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр 7
5.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр. 8
6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ 9
7. ЗӨВЛӨМЖ 9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
СУАЖЗГ	Соёл, урлаг, аялал жуулчлал залуучуудын газар

1.ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын дэргэдэх “Дотоод аудитын хорооны 2025 оны төлөвлөгөө”, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/76 дугаар тушаалаар батлагдсан “Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн ХШҮДАГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, гэрээт дотоод аудитор О.Пүрэвсүх нар Дорнод аймгийн СУАЖЗГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Засгийн газрын 2021 оны 168 дүгээр тогтоолын дагуу тус аймагт Соёлын хэлтсийг анх байгуулсан. Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоол, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны 04 дүгээр тушаалын дагуу Дундговь аймгийн Соёл, урлагийн газрыг 11 орон тоотойгоор шинэчлэн байгуулсан.

Байгууллагын регистрийн дугаар 3391981, үндсэн үйл ажиллагааны 100070034003, нэмэлт санхүүжилтийн 100070034401 тоот харилцах данснуудаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/23 дугаар захирамжаар Б.Маналжавыг Дорнод аймгийн Соёлын хэлтсийн даргын албан тушаалд анх томилж, улмаар Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн Б/24 дүгээр тушаалаар Б.Мангалжавыг Соёл, урлагийн газрын даргаар шинэчлэн томилсон байна. Аудитын хамрах хугацаанд дээрх шийдвэрийн дагуу нэгдүгээр гарын үсгийн Б.Мангалжав одоог хүртэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогчоор 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/14 дүгээр тушаалаар томилогдсон С.Чулуун-Эрдэнэ нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны хагас болон III улирлын санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

<u>Бүтэц зохион байгуулалт</u>

Соёлын сайд /хуучин нэрээр/ -ын 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Аймгийн Соёл, урлагийн газар”-ыг 2 хэлтэс, орон тооны дээд хязгаарыг 11 байхаар тогтоосон. Улсын Их Хурлын ээлжит сонгуулын үр дүнгээр байгуулагдсан Засгийн газрын бүтцээр тус байгууллагад аялал жуулчлал, залуучуудын салбар нэгдэж 3 орон тоо нэмэгдсэн байна.

Засаглах удирдлага: Байгууллагын дүрмийн 1.6-д газар нь орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байж болох тухай заалтын дагуу даргын дэргэд 4 зөвлөл ажиллаж байна. Үүнд: 2022 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн А/08 тушаалаар “Өмч хамгаалах комисс”, 2022 оны 04 дүгээр сарын 22-ны А/03 дугаар тушаалаар “Залуучуудын хөгжлийн зөвлөл”, мөн өдрийн А/04 дүгээр тушаалаар “Байгууллагын эцэг, эхийн зөвлөл”, 2022 оны 4 дүгээр сарын 25-ны А/05 дугаар тушаалаар “Ёс зүйн зөвлөл” тус тус байгуулагдсан байна.

Гүйцэтгэх удирдлага: Захиргаа удирдлагын хэлтэс-1, Соёл урлагийн хэлтэс-1, -16 хүний орон тоотой.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны III улирлын байдлаар тасалбар болгон санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-нд байдалд санхүүгийн дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүгийн аудит хийж “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгч тул уг тайлангийн хамарсан хүрээгээр энэхүү хяналт шалгалтыг хязгаарлаж, итгэл хүлээлгэсэн болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Аудитын дүнгээр 2 нэр төрлийн алдаа зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж хүргүүлсний хэрэгжилт 83.3 хувьтай байна. Үүнд:

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн /мян.төг/	Хэрэгжүүлсэн байдал
Албан шаардлага	Байгууллагын төсвийн бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас байгууллагын ажилчдад өдөр тутмын хэрэглээний цэвэршүүлсэн баллонтой усыг, хоол, унааны хөнгөлөлттэй давхардуулан олгосон байна.	818.0	Байгууллагын 2025 оны мөнгөн гүйлгээний журналд хяналт хийхэд ажилчдын өдөр тутмын хэрэглээний цэвэршүүлсэн усны зардалд 146.0 мянган төгрөгийг эхний улиралд зарцуулсан бөгөөд санхүүгийн аудитын дүгнэлт гарснаас хойших хугацаанд цэвэр ус худалдан авсан гүйлгээ хийгдээгүй тул зөвлөмжийг хэрэгжилт хангалттай гэж дүгнэв. **Биелэлт 100 хувь**
Зөвлөмж	Дорнод аймгийн сумдын Соёлын төвүүдэд манаач, жижүүрүүд нь хүйтний улиралд галчийн ажлыг давхар гүйцэтгэдэг, 3 ээлжээр ажилладаг, 24 цагаар тасралтгүй ажилладаг нийтлэг зөрчил илэрсэн.	-	Соёлын төвүүдэд манаач, жижүүрүүд нь хүйтний улиралд галчийн ажлыг давхар гүйцэтгэдэг, 3 ээлжээр ажилладаг, 24 цагаар тасралтгүй ажилладаг нийтлэг зөрчилийн талаар удирдах ажилтан нарт чиглэл өгч ажиллав. **Биелэлт 75 хувь**
		818.0	

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

3.1. Засаглалын удирдлагын талаар

Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Байгууллагын даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/04 тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2023 оны эхний улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “А” индексийн 6, боловсон хүчний чиглэлээр “Б” индексийн 5, нийт 11 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор ерөнхий 3 асуултын хүрээнд 7 дэд асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Дотоод хяналтын тухайд байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төсвийн төлөвлөлт

Байгууллагын 2023 оны төсвийн төслийг 211,939.8 мянган төгрөгөөр боловсруулан Соёлын яаманд хүргүүлсэн.

Сангийн яамнаас тус байгууллагын 2023 оны төсвийг 249,567.0 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газраас 2023 оны эхнээс цалинг шинэчлэн тогтоож нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Тус байгууллагын 2023 оны урсгал санхүүжилтэд улсын төсвөөс 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 249,567.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

- Үндсэн үйл ажиллагааны зардалд 249,188.6 мянган төгрөг
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуллын зардалд 378.4 мянган төгрөг

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2025 оны эхний улиралд улсын төсвөөс 65,028.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харуулав.

Байгууллагын 2025 оны III улирлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн дүн:

Эдийн засгийн зардлын ангилал арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны зардал	64,933.7	64,203.9	729.8	98.9%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	94.5	31.5	63.0	33.3%
Дүн	65,028.2	64,235.4	792.8	98.8%

Тус байгууллагын 2025 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,439.1 мянган төгрөгөөр буюу 8.92 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,246.6	4,246.65
Авлага			-
Бараа материал	11,781.4	13,333.7	1,552.30
Үндсэн хөрөнгө	137,237.2	124,999.1	(12,238.02)
Нийт хөрөнгө	**149,018.6**	**142,579.5**	**(6,439.1)**
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	149,018.6	142,579.5	(6,439.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**149,018.6**	**142,579.5**	(6,439.1)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,246.6 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,552.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 14,476.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 12,923.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 124,999.1 мянган төгрөг болж 12,238.02 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацааны элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 142,579.5 мянган төгрөг болж, 6,439.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2025 оны III улиралд улс, орон нутгийн төсвөөс 932,899.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харуулав.

Байгууллагын 2025 оны III улирлын байдлаарх
төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүн

№	Орлого, зардлын эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
I	**НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**1,042,263.4**	**932,899.2**	**109,364.1**	**89.5**
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	626,395.9	517,031.8	109,364.1	82.5
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	32,000.0	32,000.0	-	100.0
81901	Соёл урлаг хөгжүүлэх	358,867.4	358,867.4	-	100.0
81943	Монголын түүх, соёл, үндэсний урлагийг гадаад, дотоодод түгээн сурталчилах хөтөлбөр	25,000.0	25,000.0	-	100.0
II	**НИЙТ ЗАРДАЛ**	**1,042,263.4**	**858,303.9**	**183,959.5**	82.4
	Үндсэн данс	**623,586.8**	**499,479.2**	**124,107.6**	**839.4**
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл	505,687.7	413,171.5	92,516.2	81.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал	63,267.2	51,634.9	11,632.3	81.6
210401	Бичиг хэрэг	5,980.7	4,031.8	1,948.9	67.4
210402	Тээвэр, шатахуун	2,533.0	2,533.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэт	3,587.8	1,557.7	2,030.1	43.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	1,995.8	1,590.1	405.7	79.7
210702	Дотоод албан томилолт	2,875.4	2,875.4	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	3,750.2	5,205.0	- 1,454.8	138.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,909.0	1,909.0	-	100.0
2108	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	32,000.0	14,970.8	17,029.2	46.8
	Нэмэлт данс	**418,676.6**	**358,824.7**	**59,851.9**	**383.3**
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл ура	31,047.1	31,047.1	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатга	3,762.0	3,762.0	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	358,867.4	299,015.5	59,851.9	83.3
210801	Бараа үйлчилгээний бусад зардал	25,000.0	25,000.0	-	100.0

5. АУДИТЫН ҮР ДҮН

5.1. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр

Илэрсэн асуудал 1. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцон олгосон.

Дотоод аудитын чиглэл: Бүтэц орон тоо, цалин тогтоолт, бодолт, олголт, цалингаас суутгасан ХХОАТ, НДШ –ийн өр, авлагын бүртгэл хөтлөлтийг хянаж үр нөлөөг үнэлэх.

Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн дагуу олгосон нэмэгдлийн хувь хэмжээг хянан шалгахад 2 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2 хувиар зөрүүтэй Хүний нөөцийн программд бүртгэн цалингийн нэмэгдлийг илүү олгосон байна.

Нэр	Албан тушаал	Үндсэн цалин	Төрийн алба хаасан хугацааны		Олговол зохих	Илүү олгосон дүн
			Нэмэгдлийн хувь	Мөнгөн дүн		
С.Чулуун-Эрдэнэ	Нягтлан бодогч	1,559.0	18	2,619.1	2,338.5	280.6
Д.Наранчимэг	Мэргэжилтэн	1,283.0	6	599.5	369.7	229.8
Дүн				3,218.6	2,708.2	510.4

Шалгуур үзүүлэлт:	**Илэрсэн алдаа, дутагдал:**
Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2.Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:	Нэр бүхий 2 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эхний 10 сарын дүнгээр 510.4 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Шалтгаан

Байгууллагын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хувийг үнэн зөв тооцон тушаал гаргаагүй, хүний нөөцийн программд оруулаагүй үйлдэл, эс үйлдэл

Үр нөлөө

Цалингийн зардал хэтрэх, төсвийг хэмнэлтгүй зарцуулахад нөлөөлсөн үр дагавартай.

Дүгнэлт:

Төрийн алба хаасан хугацааг байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж буюу ажилтан тодорхойлж, тухайн байгууллагын төсвийн шууд захирагчийн тушаалаар энэ журмын 2-т заасны дагуу нэмэгдэл олгох хувийг тогтооно гэсэн заалтыг үнэн зөв хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж:

1. Төрийн алба хаасан хугацааг журмын дагуу зөв тодорхойлж, нэмэгдэл олгох хувийг баримтлан олгож байх.

Илэрсэн асуудал 2. Хавсран түр орлон гүйцэтгэгчийн нэмэгдэл хөлсийг илүү олгосон байна.

Дотоод аудитын чиглэл: Бүтэц орон тоо, цалин тогтоолт, бодолт, олголт, цалингаас суутгасан ХХОАТ, НДШ –ийн өр, авлагын бүртгэл хөтлөлтийг хянаж үр нөлөөг үнэлэх.

Нөхцөл байдал:

1. СУАЖЗГ-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Б/09 дүгээр тушаалаар Соёлын хяналтын улсын байцаагчийн албан тушаалд ажиллаж байсан Б.Ганзориг нь Булган сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар томилогдож чөлөөлөгдсөн тул мөн өдрийн Б/10 дугаар тушаалаар хэлтсийн дарга Л.Идэрбатыг Соёлын хяналтын улсын байцаагчийн албан тушаалыг түр орлон гүйцэтгэгчээр томилж, 40 хувийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэн, 2025 оны 10 дугаар сарын байдлаар 3,078.0 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.
2. СУАЖЗГ-ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар Төсөв, хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтний албан тушаалд ажиллаж байсан Д.Өнөртуяа нь жирэмсний болон амаржсаны амралт авч чөлөөлөгдсөн тул мөн өдрийн Б/13 дугаар

тушаалаар ХШҮ, статистик мэдээ хариуцсан Г.Амартайванг түүний албан тушаалыг түр орлон гүйцэтгэгчээр томилж, 40 хувийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэн, 2025 оны 10 дугаар сарын байдлаар 2,232.3 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.

/мянган төгрөг/

№	Нэр	Ажлын байр	Үндсэн цалин	Түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалин	Сард олгосон нэмэгдэл хөлс	Нийт олгосон дүн
1	Л.Идэрбат	Хэлтсийн дарга	1,693.0	1,539.0	615.6	3,078.0
2	Г.Амартайван	Мэргэжилтэн	1,283.0	1,399.0	559.6	2,232.3
						5,310.3

Шалгуур үзүүлэлт:

Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.1. Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно.

Илэрсэн алдаа, дутагдал:

Сул орон тоо гарсан үед эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүү олгох журмыг зөрчиж 1,810.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон алдаа гаргасан.

/мянган төгрөг/

2 албан тушаалын цалингийн зөрүү	Хавсран ажилласан хугацаа	Олговол зохих нэмэгдэл хөлс	Илүү олгосон
154.0	5 сар	2,154.8	923.2
116.0	5 сар	1,345.1	887.2
			1,810.4

Шалтгаан

Байгууллагын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын хавсран ажиллах нэмэгдэл хөлс олгох журмыг мөрдөж тушаал гараагүй үйлдэл, эс үйлдэл

Үр нөлөө

Цалингийн зардал хэтрэх, төсвийг хэмнэлтгүй зарцуулахад нөлөөлсөн үр дагавартай.

Дүгнэлт:

Сул орон тоо гарсан албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхдээ нэмэгдэл хөлсийг илүү олгосон.

Зөвлөмж:

1. Эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид нэмэгдэл хөлсийг цалингийн зөрүүгээр эхний 2-оос 6 сарын хугацаанд тооцон олгож байх.

5.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр.

Илэрсэн асуудал 4. Таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллүүдийг иж бүрэн, үнэн зөв, бодиттой байх шаардлагыг хангаж мэдээлээгүй байна.

Дотоод аудитын чиглэл: 3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт.

Шалгуур үзүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

Илэрсэн алдаа, дутагдал:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээ талбарт: Тайлант хугацаанд 13 удаагийн 122.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлсэн боловч 12 удаагийн 107.9 сая төгрөгийн гүйлгээг тухай бүр буюу 7

6.3.3.төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар; Шилэн дансны тухай хуулийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн **түншлэлийн гэрээ**, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	хоногийн дотор мэдээлэх хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн. • Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ талбарт. Тайлант хугацаанд 26 удаагийн 874.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлэхээс 7-р сарын санхүүжилтийн 49.9 сая төгрөгийг мэдээлээгүй, 6-р сард тухай бүр буюу 7 хонгийн дотор мэдээлэх хуулийн хугацааг хоцроож мэдээлсэн, 8-р сарын санхүүжилтийн 2 гүйлгээг нэгтгэж мэдээлсэн, 9-р сарын санхүүжилтийн орлогыг 7.0 сая төгрөгөөр илүү мэдээлсэн байна. • Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт талбарт Тайлант хугацаанд иргэн хуулийн этгээдээс худалдан авсан 13 удаагийн 122.9 сая төгрөгийн мэдээлээгүй, энэ талбарт санхүүжилтийн орлогыг мэдээлсэн алдаа гаргасан. • Байгууллагын даргын хөрөнгө зарцуулсан шийдвэрийг мэдээлээгүй байна
Шалтгаан	
Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө	
Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.	
Дүгнэлт: Тус байгууллага нь 2025 оны 3-р улирлын байдлаар шилэн дансанд 23 нэр төрлийн мэдээллийг 140 талбарт мэдээлэхээс хуулийн хугацаа хоцроож 2 талбарт мэдээлсэн, мэдээллийн үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 15 алдаа гаргасан байна.	
Зөвлөмж: 1. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;	

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны III улирлын байдлаарх төсөв санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэн дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

Аудитаар илэрсэн алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг цаглаварт хугацааны дотор ХШҮДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг мэдэгдье.

7. ЗӨВЛӨМЖ

Төсвийн шууд захирагч, газрын дарга Б.Мангалжав танаа		Хугацаа
Зөвлөмж 1.	Төрийн алба хаасан хугацааг журмын дагуу зөв тодорхойлж, нэмэгдэл олгох хувийг баримтлан олгож байх;	2025 оны 12-р сарын 25-ны дотор

Зөвлөмж 2.	Эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид нэмэгдэл хөлсийг цалингийн зөрүүгээр эхний 2-оос 6 сарын хугацаанд тооцон олгож байх;	

Нягтлан бодогч С.Чулуун-Эрдэнэ танд

Зөвлөмж 2.	Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;	2025 оны 12-р сарын 25-ны дотор

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ